

## НИЙСЛЭЛИЙН 2017 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### Нийслэлийн Дотоод аудитын алба

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжаар “Нийслэлийн Дотоод аудитын алба” байгуулагдсан. Нийслэлийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний А/635, 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/830 захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар өөрчлөгдсөнтэй холбогдуулан, байгууллагын даргын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01, 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/08 тушаалаар байгууллагын бүтцийг оновчтой болгох, ажлын ачааллыг жигдрүүлэн нягтруулах үүднээс бүтэц, орон тоо, ажлын байрны жагсаалтыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна.

2017.01.25-нд байгууллагын дарга орлогч дарга болон нэгжийн дарга нартай, нэгжийн дарга нар албан хаагчидтай 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулснаар хэлтэс, албан хаагчдын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. 2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21 албан хаагчтай үр дүнгийн гэрээ, 3 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэвийг шинээр 1 албан хаагч авч, 6 албан хаагчийн зэрэг дэв, 1 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг тус тус ахиулж, мөн нэг албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөлөө.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх дунд хугацааны “Хүний нөөцийн сургалтын хөтөлбөр”, 2017 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр 2017 оны төсөвт 5,5 сая төгрөгийг батлуулснаас мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, хуульчийн тасралтгүй боловсролын сургалтад нийт 1,3 сая төгрөгийг зарцуулсан. Сангийн яам, НЗДТГ болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан төрөл бүрийн сургалтуудад давхардсан тоогоор нийт 150 гаруй албан хаагчийг хамруулсан.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 4.2-т “Дотоод аудитын нэгж нь төсвийн ерөнхийлөн захирагчид ажлаа хариуцан тайлагнана.”, 7.6-д “Дотоод аудитын нэгжийн дарга дараах асуудлыг Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулж тайлагнана:

- 7.6.1. гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын дүн;
- 7.6.2. нэгжийн жилийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн явц;
- 7.6.3. холбогдох акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн явц;
- 7.6.4. хөндлөнгийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явц;

7.6.5. аудитад хамрагдсан байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарах асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал.” гэсний дагуу зөвхөн Дотоод аудитын хороо, төсвийн ерөнхийлөн захирагч буюу нийслэлийн Засаг дарга, тухайн аудит хийлгэсэн байгууллагын удирдлагад танилцуулдаг ч Монгол Улсын Их Хурлаас баталсан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг байгууллагын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, “Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”, авлигын эсрэг сургалтын материалуудыг байгууллагын цахим хуудсаар болон албан хаагчдын цахим хаягаар танилцуулж сурталчилсан бөгөөд авлигын эсрэг зурагт хуудсуудыг байгууллагын самбар дээр байнга байршуулсан.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, байгууллагын болон албан хаагчдын мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2016 оны үйл ажиллагааны 12 төрлийн тайлан, байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, 2017 оны сургалтын төлөвлөгөө, агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын төлөвлөгөө, цаг үеийн мэдээ мэдээллүүд, дотоод аудитын талаарх ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар зэрэг мэдээллийг нийтэлсэн.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын [www.internalaudit.ub.gov.mn](http://www.internalaudit.ub.gov.mn) цахим хуудсанд санхүүгийн тайлан нийт 3 удаа, төсвийн гүйцэтгэлийн мэдээ 9, аудитын дүгнэлт 1, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн авч арга хэмжээ 1, тухайн байгууллагын жилийн төсөв 1, холбогдох материалыг нийтэлсэн. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн холбогдох 107 мэдээллийг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон жилийн төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, санхүүгийн тайлан, таван сая төгрөгөөс дээш гүйлгээний мэдээлэл, бусад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан аваагүй болно.

2017 оны аудитын төлөвлөгөөний дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 29 байгууллагад хийсэн аудитын ажлын хүрээнд нийт 148,153.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 120,487.7 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 1,851.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 17,765.1 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгсөн. Дээрх байгууллагуудын хууль тогтоомжийн хэрэгжилт, засаглалын тогтолцоо, санхүүгийн

сахилга батыг сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 16 дугаар удирдамжийн хүрээнд Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн үзлэг шалгалтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацааг хамруулан нийслэлийн ТЕЗ-ийн харьяа төсөвт 50, аж ахуйн тооцоот 19 нийт 69 байгууллагад гүйцэтгэсэн. Аудитын баг Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэхдээ <http://shilendans.gov.mn/> цахим хуудсанд харьяа байгууллагуудын байршуулсан мэдээллийг аудитын дуусгавар хугацаа болох 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар баримтжуулсан ба цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн болон бусад холбогдох баримтуудтай харьцуулан тулгаж бүрэн, үнэн зөв эсэхийг магадласан.

Энэхүү үзлэг шалгалтаар тус хууль болон журмыг хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлж байгаа нийт 4 байгууллагад албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх 2017 оны нэгдсэн шалгалтаар илэрсэн алдаа зөрчлүүдийн дийлэнх хувь нь тухайн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж, холбогдох ажилтан, албан хаагчид шинэчлэгдсэнтэй холбоотойгоор гарсан нь аудитын явцад ажиглагдсан.

Аудитын баг байгууллагуудад ажиллах явцад тухай бүр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан ба цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан болно.

АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 12 албан хаагчийн 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайлан мэдээг гаргаж өгсөн. Оны эхний 10 сарын байдлаар аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 85 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэсэн.

Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулах нууц санал хураалт явуулснаар ёс зүйн хорооны даргаар орлогч дарга Д.Энхбат, гишүүдээр Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн дарга Ж.Жамбалдорж, ахлах аудитор Д.Нансалмаа нарыг байгууллагын даргын 2017 оны 02 дугаар сарын 09-ний А/04 тушаалаар томилсон. 2017 оны эхний 10 сарын байдлаар албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар гомдол, санал ирээгүй байна.

ХЯНАСАН:  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ

2015, 2016, 2017 ОНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ  
БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН /сая.төг-р/

Аудитын төрөл	Аудит хийсэн байгууллагын тоо			Зөрчлийн нийт дүн		
	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/
Санхүүгийн аудит	21	11	10	17,787.2	7,653.2	29,236.9
Гүйцэтгэл, нийцлийн аудит	21	21	12	12,312.2	3,537.1	1,976.9
Бусад /хамтарсан, сэдвийн/			7			116,940.0
Дүн	42	32		30,099.4	11,190.3	148,153.8

Аудитын төрөл	Өгсөн зөвлөмж											
	Тоо			Төсөвт буцаан төвлөрүүлэх			Данс бүртгэлд тусгах, залруулах			Давтан гаргахгүй байх		
	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/	2015 он	2016 он	2017 он /3 дугаар улирлын байдлаар/
Санхүүгийн аудит	71	54		0	4.5	424.9	1,281.8	10.9	1,851.7	16,505.4	7,637.8	26,745.6
Гүйцэтгэл, нийцлийн аудит	320	209		28.3	12.5	14.3	1,623.5	806.2	-	10,660.4	2,718.4	1,962.6
Бусад /хамтарсан, сэдвийн/						17,325.9			-			91,779.5
Дүн	391	263		28.3	17.0	17,765.1	2,905.3	817.1	1,851.7	27,165.8	10,356.2	120,487.7